




МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

**Автотээврийн хэрэгслийн техникийн хяналтын
Үзлэгийн төв. Ангилал. Ерөнхий шаардлага**



АЛБАН ХЭВЛЭЛ

**Стандарт, хэмжил зүйн газар
Улаанбаатар хот
2020 он**

ӨМНӨХ ҮГ

Стандарт, хэмжил зүйн газар (СХЗГ) нь Олон Улсын Стандартчиллын байгууллагын гишүүн бөгөөд үйл ажиллагааныхаа хүрээнд төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран үндэсний стандартчиллын бодлогыг хэрэгжүүлэх ажил эрхэлдэг.

Стандартын төсөл боловсруулах ажлыг салбарын стандартчиллын Техникийн хороо (ТХ), Дэд хороо (ДХ) эрхлэн гүйцэтгэдэг бөгөөд Техникийн хорооны хурлаар хэлэлцэж 75 хувиас доошгүй дэмжиж зөвшилцсөн төслийг Стандартчиллын үндэсний зөвлөлөөр хэлэлцэн, тогтоолоор баталснаар хүчин төгөлдөр болно.

Энэхүү стандартыг 2010 оны Тээврийн стандартчиллын хөтөлбөрийн дагуу Автотээврийн газрын хяналт шалгалтын хэлтсийн дарга, зөвлөх инженер С.Батболд, оношлогоо хариуцсан мэргэжилтэн, техникийн ухааны магистер, мэргэшсэн инженер П.Мөнхбат, сургалт хариуцсан мэргэжилтэн, зөвлөх инженер Д.Энх-Амгалан нар хамтран боловсруулсан болно. 2020-2021 оны Автотээврийн стандартчиллын төлөвлөгөөны дагуу ЗТХЯам шинэчлэн боловсруулж батлав.

Уг стандартын төслийг СХЗГ-ын дэргэдэх Автотээврийн стандартчиллын техникийн хороо (ТХ15)-оор хэлэлцэж зөвшилцсөн болно.

Энэхүү стандартыг СХЗГ-ын стандартын шинжээч, мэргэжилтэн Д.Төрмөнх Монгол Улсын стандартчиллын тогтолцооны суурь стандарт MNS 1.1 : 2006, MNS 1.2 : 2006-ын дагуу хянав.

Стандарт, хэмжил зүйн газар (СХЗГ)
Энх тайваны өргөн чөлөө 46А
Шуудангийн хаяг
Улаанбаатар-13343, Ш/Х - 48
Утас: 976-51-263860, 51-266754, Факс: 976-11-458032
E-mail: standardinform@masm.gov.mn
www.estandart.gov.mn
© СХЗГ, 2020

Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн дагуу энэхүү стандартыг бүрэн, эсвэл хэсэгчлэн хэвлэх, олшруулах эрх нь гагцхүү СХЗГ (Стандартчиллын төв байгууллага)-т байна.

МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

Ангилалтын код 43.020

Автотээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэгийн төв. Ангилал. Ерөнхий шаардлага

Vehicle Inspection Station. Classification. General requirement

СТАНДАРТЧИЛАЛ, ХЭМЖИЛ ЗҮЙН ГАЗАР

СТАНДАРТЫН
MNS 5044 : 2020
БҮЛЭВЭРЭЭМГИЙН
ОЛГОСОН ХУВЬ

MNS 5044 : 2010-ийн оронд

МОНГОЛ УЛСЫН УЛСЫН СТАНДАРТЫН ТӨВ БОЛОН
МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТЫН ХЭМЖИЛ ЗҮЙН ГАЗАР

Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2020 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн С/64 дүгээр тушаалаар батлав.

Энэ стандарт нь 2021 оны 01 дүгээр сарын 28-ний өдрөөс эхлэн хүчинтэй.

1. Зорилго

Энэхүү стандартын зорилго нь автотээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэг явуулах ажлыг зохион байгуулах, нийтлэг шаардлага, журам тогтооход төр, захиргааны болон бусад байгууллагаас хяналт тавих, ажил үйлчилгээнд үүсэх харилцааг зохицуулахад оршино.

2. Хамрах хүрээ

Энэхүү стандарт нь автотээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэг хийж, дүгнэлт гаргах эрх бүхий байгууллагын болон ажил үйлчилгээний шаардлагыг тодорхойлоход хамаарна.

Энэхүү стандартыг автотээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэг хийх техникийн хяналтын үзлэгийн төвүүд болон тэдгээрийн ажил, үйлчилгээнд хяналт тавих эрх бүхий байгууллага, албан тушаалтан мөрдөж хэрэглэнэ.

3. Норматив эшлэл

Энэхүү стандартыг боловсруулахад дараах баримт бичгүүдийг ашигласан. Эдгээр баримт бичигт өөрчлөлт орсон тохиолдолд хамгийн сүүлчийн албан ёсны эх материалаас эш татаж хэрэглэнэ. Үүнд:

3.1 MNS 5342 - Авто зогсоол, ангилал, ерөнхий шаардлага

3.2 MNS 3831 - Техникийн найдвартай ажиллагааны үндсэн нэр томъёо, тодорхойлолт, тайлбар толь

3.3 MNS ISO/PAS 3930 Автотээврийн хэрэгслийн ажилласан хий дэх хорт бодисыг хэмжих багаж. Хэмжил зүйн болон техникийн шаардлагууд, туршилт явуулах болон хэмжил зүйн хяналт

3.4 БНБД21-01-02, Барилга байгууламжийн галын аюулгүй байдлын норм, дүрэм.

3.5 БНБД. 31-03-03, Олон нийт, иргэний барилгын норматив, дүрэм.

3.6 БНБД 32-01-04, Хот суурины гудамж, зам төлөвлөлт.

3.7 БНБД3.05.06-90, Цахилгаан техникийн ажил.

4. Нэр томьёо, тодорхойлолт

Энэ стандартад хэрэглэсэн нэр томьёо, тодорхойлолтыг дараах утгаар ойлгож хэрэглэнэ.Үүнд:

4.1

техникийн хяналтын үзлэг

автотээврийн хэрэгслийн техникийн байдлыг тусгай багаж хэрэгсэл, тоног төхөөрөмж ашиглан, үзлэгийн инженер мэргэжлийн ур чадвар, дадлага туршлагад тулгуурлан, стандартын шаардлагыг хангаж байгаа эсэхэд үзлэг хийж шалгах, тодорхойлох, үнэлэх үйл ажиллагаа

4.2

техникийн хяналтын үзлэгийн төв

автотээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэг хийж замын хөдөлгөөний аюулгүй байдлын шаардлага хангасан тухай гэрчилгээ олгох, автотээврийн хэрэгсэл эзэмшигчдэд мэргэжлийн зөвлөгөө өгөх эрх бүхий байгууллагыг.

5. Нийтлэг шаардлага

5.1 Техникийн хяналтын үзлэгийн төв нь автомашин, түүний агрегат, зангилаа, системийн техникийн байдлыг шалгах, техникийн хяналтын үзлэг хийхэд хэмжих, оношлох, шалгах, багаж хэрэгсэл, эсвэл шалгах ажлын технологийн дараалал нь харилцан адилгүй байж болох боловч гаргасан дүгнэлт нь ижил нөхцөл, шаардлагыг хангасан байна.

5.2 Техникийн хяналтын үзлэгийн төв нь техникийн хяналтын үзлэгийн технологийн карт, техникийн шаардлагатай бусад баримт бичгийг боловсруулж мөрдөнө.

5.3. Техникийн хяналтын үзлэгийн төв нь радио долгионы давтамж ашиглан бүртгэх ISO 18000 стандартын шаардлагад нийцсэн RFID (Radio-frequency identification-Радио долгионы давтамж ашиглан бүртгэх) -ийн шошго уншигч төхөөрөмжөөр тоногловсон байна.

5.4. Үзлэгийн төв нь RFID (Radio-frequency identification-Радио долгионы давтамж ашиглан бүртгэх) -ийн шошго уншигч төхөөрөмжид бүртгэгдсэн тээврийн хэрэгслийн мэдээллийг төв серверт дамжуулах цахим сүлжээнд холбогдсон байна.

5.5. Үзлэгийн төв нь тээврийн хэрэгслийн улсын дугаар болон ерөнхий байдал, үзлэгийн үйл явц тод, тодорхой харагдахаар хяналтын камераар тоногловсон байх бөгөөд санах ой нь 30-аас дээш хоног архивлан хадгалах боломжтой байна.

5.6. Энэхүү стандартын 5 дахь бүлэгт заасан шаардлагууд нь техникийн хяналтын үзлэгийн явуулын төвд нэгэн адил хамаарна.

6. Автотээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэг хийх байгууллагын ангилал

6.1 Сорилт, баталгаажуулалт, техникийн хяналтын итгэмжлэгдсэн тохирлын үнэлгээний байгууллага нь:

- А. Сорилт, баталгаажуулалтын итгэмжлэгдсэн лаборатори
- Б. Техникийн хяналтын итгэмжлэгдсэн төв гэж ангилна.

6.1.1 Сорилт, баталгаажуулалтын итгэмжлэгдсэн лаборатори нь автотээврийн хэрэгслийн техникийн байдлыг оношлох тоноглол, багаж хэрэгслийн хэмжилтийн алдаа, нарийвчлалыг тодорхойлох, харьцуулалт хийх боломж бүхий олон улсын хэмжилзүйн стандартын шаардлага хангасан, эталон багаж хэрэгсэл, тоноглолтой, ижил нөхцөлтэй техникийн хяналтын үзлэгийн төвүүдийн оношлох багаж хэрэгсэл, тоноглолыг шалгаж баталгаажуулах, хүний нөөцийн мэргэжилтэнг сургаж дадлагажуулах эрх бүхий байгууллага байна.

6.1.2 Техникийн хяналтын үзлэгийн төвийг үйл ажиллагааны хэлбэрээс нь хамааруулж дараах төрөлд ангилна. Үүнд:

- а. Техникийн хяналтын үзлэгийн суурин төв
- б. Техникийн хяналтын үзлэгийн явуулын төв

6.1.2.1 Техникийн хяналтын үзлэгийн суурин төв нь автомашин олноор төвлөрсөн, автозамын хөдөлгөөний нягтрал ихтэй, экологийн шаардлага өндөр тавигддаг хот, суурин газрын нутаг дэвсгэрт автотээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэгийг суурьшсан нөхцөлд явуулна.

6.1.2.2 Техникийн хяналтын үзлэгийн явуулын төв нь автотээврийн хэрэгслийн тоо харьцангуй цөөн, хөдөлгөөний нягтрал багатай, хот суурин газраас алслагдсан нутагт автотээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэгийг хөдөлгөөнт, нүүдлийн нөхцөлд явуулна.

6.1.3 Техникийн хяналтын үзлэгийн төв нь дээрх 2 төрлийн аль нэгээр дагнасан, эсвэл хослосон хэлбэрээр байж болно. Автотээврийн хэрэгслийн төрлөөр ачааны болон суудлын, тусгай зориулалтын автомашины, автобусны гэх мэт төрөлжсөн, эсвэл хосолсон хэлбэрийн байж болно.

6.2 Техникийн хяналтын үзлэгийн төв нь техникийн хяналтын үзлэг хийх зориулалтын дараах техникийн бааз, барилга байгууламжтай байна. Үүнд:
- технологийн тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл,
- үйлдвэрлэл, үйлчилгээний байр, зогсоол талбай.

6.2.1 Технологийн тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл

6.2.1.1 Техникийн хяналтын үзлэгийн төв нь автомашин, түүний агрегат, зангилаа, системийн техникийн байдлыг шалгаж, оношлоход шаардлагатай тоног төхөөрөмж, багаж хэрэгслээр технологийн картын дагуу тоноглогдсон байна.

6.2.1.2 Техникийн хяналтын үзлэгийн төвд зайлшгүй байх тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл нь 1-р хүснэгтэд заасан шаардлагыг хангасан байна.

1-р хүснэгт - Техникийн хяналтын үзлэгийн суурийн төвийн тоног төхөөрөмж, багаж хэрэгсэлд тавих шаардлага

Д/д	Тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн нэр	Зориулалт	Техникийн шаардлага
1	Дугуйн хийн даралт хэмжигч	Дугуйн хийн даралт хэмжинэ	Хэмжих хязгаар: 0-2000 Па Хэмжих нарийвчлал: 10 Па Хэмжилтийн алдаа: 5 %
2	Тоормосны стэнд	Тоормосны идэвхжилийг хэмжинэ	Тэнхлэгт оногдох даралт: Ачааны автомашинд - 12000 кг Суудлын автомашинд - 3500 кг Хэмжих нарийвчлал: 10 daN Хэмжилтийн алдаа: 5%
3	Дугуйн хээний гүн хэмжигч	Дугуйн хээний гүн хэмжинэ	Хэмжих нарийвчлал: 0,1 мм Хэмжилтийн хязгаар: 0-30 мм
4	Урд гэрлийн тусгал хэмжих багаж	Их гэрлийн тусгалыг хэмжинэ.	Хэмжилтийн хязгаар: дээд/доод: 3°/3° баруун/зүүн: 3°/3° гэрлийн тусгалын чадал: 0-250000 cd буюу 0-400 люкс байна.
5	Бензин хөдөлгүүрийн утаа хэмжигч (газоанализатор)	Хөдөлгүүрийн утааны найрлага дахь хорт бодисыг хэмжинэ. Нүүрстөрөгчийн дутуу исэл CO	Хэмжилтийн хязгаар: 0-9,99% Хэмжих нарийвчлал: 0,01%
		Нүүрстөрөгчийн исэл CO ₂	Хэмжилтийн хязгаар: 0-19,9% Хэмжих нарийвчлал: 0,1%
		Нүүрсустөрөгч CH	Хэмжилтийн хязгаар: 0-10000 ppm Хэмжих нарийвчлал: 1 ppm
		Хүчилтөрөгч O ₂	Хэмжилтийн хязгаар: 0-25,0% Хэмжих нарийвчлал: 0,1%
		Тосны температур, C°	Хэмжилтийн хязгаар: 45°C-аас 160°C Хэмжих нарийвчлал: 2°C
		Агаарын илүүдлийн коэффициент, λ	Хэмжилтийн хязгаар: 0,50-2,500 Хэмжих нарийвчлал: 0,001
		Тахир голын эргэлтийн давтамж	Хэмжилтийн хязгаар: 0-6000 мин ⁻¹ Хэмжих нарийвчлал: 100 мин ⁻¹
6	Дизель хөдөлгүүрийн тортог хэмжигч	Дизель хөдөлгүүртэй автомашины утааны тортогжилт хэмжинэ	Утааны тортогжилтыг хэмжиж дүнг %-оор болон К үзүүлэлтээр илэрхийлэх, хэмжилтийн дүнг хэвлэх боломжтой, RS 232 оролттой
		Тортогжилт	Хэмжилтийн хязгаар: 0-100% Хэмжих нарийвчлал: 0,1%
		К үзүүлэлт	Хэмжилтийн хязгаар: 0-9.99м ⁻¹ Хэмжих нарийвчлал: 0.01м ⁻¹
		Тосны температур	Хэмжилтийн хязгаар: 0-160°C Хэмжих нарийвчлал: 1 °C
		тахир голын эргэлтийн давтамж	Хэмжилтийн хязгаар: 0-9999 мин ⁻¹ Хэмжих нарийвчлал: 1 мин ⁻¹
7	Шуугиан хэмжигч (виброметр)	Дуу чимээний түвшинг хэмжихдээ А аргыг хэрэглэнэ	Хэмжилтийн хязгаар: өндөр түвшинд: 70 Дб –аас 140 Дб

			нам түвшинд: 30 Дб-аас 90 Дб Хэмжих нарийвчлал: 1.0 Дб
8	Өргүүр (хайчин өргүүр эсвэл сувгийн өргүүр)	Бүх жин 3,5 тонноос бага автомашины тэнхлэг өргөх өргүүр	Өргүүр: өргөх даац: 3500 кг хүртэл өргөх өндөр: 1800 мм Домкрат: өргөх даац: 3000 кг хүртэл өргөх өндөр: 250 мм
9	Сувгийн өргүүр	Бүх жин 3,5 тонноос их тээврийн хэрэгслийн тэнхлэг өргөх	өргөх даац: 10000 кг дээш өргөх өндөр: 500 мм дээш
10	Тэжээлийн системийн хий алдалтыг илрүүлэх багаж	Даралттай шахсан, шингэрүүлсэн ба ууссан хий зөөх, хадгалах зориулалттай баллон, дамжуулах хоолойн хий алдалтыг шалгана	Ажиллах температур -30оС +40оС Хэмжилтийн хязгаар: 0.07МПа (0.7 кг/см ²) - 250 МПа (25.0 кг/см ²)- хүртэл.
11	Гэрэл бууруулагч өнгөт, тунгалаг хальсны гэрэл нэвтрүүлэх чадварыг шалгах багаж(тауметр)	Автомашины салхины болон цонхны шилэнд наасан гэрэл бууруулагч өнгөт, тунгалаг хальсны гэрэл нэвтрүүлэх чадварыг шалгана	Агаарын температур: +15° +25°С Чийгшил: 40 — 80%. Хэмжилт хийх цонх нь цэвэр, хуурай байх, Агаарын даралт: 86 -106 кПа.
12	Тээврийн хэрэгслийн урд тэнхлэгийн хажуу гулсалт хэмжих хэрэгсэл	Тээврийн хэрэгслийн урд тэнхлэгийн хажуу гулсалт хэмжинэ	Хэмжих хязгаар: -/+15 дээш Хэмжих нэгж: мм/м (м/км) Хэмжилтийн алдаа: 5%

ТАЙЛБАР: Техникийн хяналтын үзлэгийн суурин төв нь 1-р хүснэгтийн 8 болон 9 дэх заалтад тусгасан тоног төхөөрөмжийн аль нэгийг сонгон ашиглах бөгөөд хүснэгтийн 10 болон 11 дэх заалтыг 2022 оын 1 дүгээр сарын 1-ний өдрөөс үйл ажиллагаандаа мөрдөнө.

2-р хүснэгт - Техникийн хяналтын үзлэгийн явуулын төвийн тоног төхөөрөмж, багаж хэрэгсэлд тавих шаардлага

д/д	Тоног төхөөрөмж багаж хэрэгслийн нэр	Зориулалт	Техникийн шаардлага
1	Дугуйн хийн даралт хэмжих багаж	Дугуйн хийн даралт хэмжинэ	Хэмжих хязгаар: 0-2000 Па Хэмжих нарийвчлал: 10 Па Хэмжилтийн алдаа: 5%
2	Тоормосны удаашрал хэмжих хэрэгсэл	Тоормосны идэвхжилтийг хэмжинэ	Хэмжих нарийвчлал: 0.02g (м/с ²) Хэмжилтийн алдаа: 5%
			Хэмжилтийн хамгийн их утга болон дундаж утгийг тооцдог
			Дэлгэцийг нарны гэрэлд унших боломжтой байх
			Зогсоолын тоормосны ажиллагаанд хэмжилт хийдэг байх
	Хэвлэх болон компьютерт мэдээллээ илгээдэг байх		
3	Дугуйн хээний гүн хэмжих багаж	Дугуйн хээний гүн хэмжинэ	Хэмжих нарийвчлал: 0,1 мм Хэмжилтийн хязгаар: 0-30 мм

MNS 5044 : 2020

4	Урд гэрлийн тусгал хэмжих багаж	Их гэрлийн тусгалыг тохируулна	Хэмжилтийн хязгаар: дээд/доод: 3°/3° баруун/зүүн: 3°/3° гэрлийн тусгалын чадал: 0- 250000 cd буюу 0-400 люкс байна.
5	Бензин хөдөлгүүрийн утаа хэмжих төхөөрөмж (газоанализатор)	Хөдөлгүүрийн утааны найрлага дахь хорт бодисыг хэмжинэ. нүүрстөрөгчийн дутуу исэл CO	Хэмжилтийн хязгаар: 0- 9,99% Хэмжих нарийвчлал: 0,01%
		нүүрстөрөгчийн исэл CO ₂	Хэмжилтийн хязгаар: 0-19,9% Хэмжих нарийвчлал: 0,1%
		нүүрстөрөгч CH	Хэмжилтийн хязгаар: 0-10000 ppm Хэмжих нарийвчлал: 1 ppm
		хүчилтөрөгч O ₂	Хэмжилтийн хязгаар: 0-25,0% Хэмжих нарийвчлал: 0,1%
		тосны температур, C°	Хэмжилтийн хязгаар: 45°C - аас 160°C Хэмжих нарийвчлал: 2°C
		агаарын илүүдлийн коэффициент, λ	Хэмжилтийн хязгаар: 0,50-2,500 Хэмжих нарийвчлал: 0,001
		тахир голын эргэлтийн давтамж	Хэмжилтийн хязгаар: 0-6000 мин ⁻¹ Хэмжих нарийвчлал: 100 мин ⁻¹
6	Дизель хөдөлгүүрийн тортог хэмжих төхөөрөмж	Дизель хөдөлгүүртэй автомашины утааны тортогжилт хэмжинэ	Утааны тортогжилтыг хэмжиж дүнг %-оор болон К үзүүлэлтээр илэрхийлэх, хэмжилтийн дүнг хэвлэх боломжтой, RS 232 оролттой
		Тортогжилт	Хэмжилтийн хязгаар: 0-100% Хэмжих нарийвчлал: 0,1%
		К үзүүлэлт	Хэмжилтийн хязгаар: 0-9.99м ⁻¹ Хэмжих нарийвчлал: 0.01м ⁻¹
		Тосны температур	Хэмжилтийн хязгаар: 0-160°C Хэмжих нарийвчлал: 1°C
		Тахир голын эргэлтийн давтамж	Хэмжилтийн хязгаар: 0-9999 мин ⁻¹ Хэмжих нарийвчлал: 1 мин ⁻¹
7	Шуугиан хэмжих багаж (виброметр)	Дуу чимээний түвшинг хэмжихдээ А аргыг хэрэглэнэ	Хэмжилтийн хязгаар: Өндөр түвшинд: 70 Дб-аас 140 Дб Нам түвшинд: 30 Дб-аас 90 Дб Хэмжих нарийвчлал: 1.0 Дб
8	Тэжээлийн системийн хий алдалтыг илрүүлэх багаж	Даралттай шахсан, шингэрүүлсэн ба ууссан хий зөөх, хадгалах зориулалттай баллон, дамжуулах хоолойн хий алдалтыг шалгана	Ажиллах температур: -30°C+40°C Хэмжилтийн хязгаар: 0.07МПа (0.7 кг/см ²) - 250 МПа (25.0 кг/см ²)- хүртэл
9	Гэрэл бууруулагч өнгөт, тунгалаг хальсны гэрэл нэвтрүүлэх чадварыг шалгах багаж (тауметр)	Автомашины салхины болон цонжны шилэнд наасан гэрэл бууруулагч өнгөт, тунгалаг хальсны гэрэл нэвтрүүлэх чадварыг шалгана	Агаарын температур: +15°C до +25°C Чийгшил: 40 - 80%. Хэмжилт хийх цонх нь цэвэр, хуурай байх, Агаарын даралт: 86-106 кПа.

6.2.2 Техникийн хяналтын үзлэгийн явуулын төв тусгай зориулалтын битүү тэвштэй, техникийн хяналтын зориулалтаар тоногдсон автомашин байна.

6.2.2.1 Техникийн хяналтын үзлэгийн явуулын төв тэжээлийн өөрийн эх үүсвэртэй, өвөл зуны аль ч улиралд ашиглах боломжтой, гэрэлтүүлэх, дулаацуулах, агааржуулах төхөөрөмжөөр тоногдсон байна.

ТАЙЛБАР: Тоормосны стөнд нь тухайн автомашины тоормосны хүчийг дугуй тус бүр дээр хэмжих, дугуй тус бүрийн тоормосны хүчийг тодорхойлох боломжтой байна.

6.2.3 Техникийн хяналтын үзлэг явуулах барилга, байгууламжид тавих шаардлага

6.2.3.1 Техникийн хяналтын үзлэг хийх барилга байгууламж, түүний инженерийн шугам сүлжээ нь автотээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэг явуулахад БНБД. 31-03-03 Олон нийт, иргэний барилгын норматив, дүрэм, БНБД 21-01-02 Барилга байгууламжийн галын аюулгүй байдал, БНБД 3.05.06-90Цахилгаан техникийн ажил, БНБД 32-01-04 Хот суурины гудамж, зам, төлөвлөлт зэрэг норм дүрэмд заасан норматив, шаардлагыг хангасан, хөдөлгүүрийн утаа зайлуулах, агааржуулах, гэрэлтүүлэх, дулаацуулах систем, галын аюулгүйн багаж хэрэгслээр бүрэн хангасан, тэдгээр нь хэвийн ажиллагаатай байна.

6.2.3.2 Галын аюулгүй байдал, эрүүл ахуй, ариун цэврийн шаардлагын дагуу цэвэр, бохир усны системд холбосон эсвэл тусгай байгууламжтай байна.

6.2.3.3 Ажилчдын хувцас солих болон амрах байр, бие засах газар, гар угаах газартай байна.

6.2.4 Зогсоол, талбайд тавих шаардлага

6.2.4.1 Зогсоол талбай нь MNS 5342 - "Авто зогсоол, ангилал, ерөнхий шаардлага" стандартад заасан шаардлагыг хангасан байна.

6.2.4.2 Хөдөлгөөний урсгалыг хангасан автомашин болон явган хүн явах хатуу хучилттай замтай байна.

7. Хүний нөөцөд тавих шаардлага

7.1 Техникийн хяналтын үзлэгийн төв нь автотээврийн салбарын мэргэжлийн байгууллага бөгөөд түүний дарга, техникийн хяналтын үзлэгийн инженер болон техникчид нь дараах шаардлагыг хангасан байна.

7.1.1 Техникийн хяналтын үзлэгийн төвийн дарга нь автотээврийн салбарын мэргэжилтэй, тухайн салбарт 5-аас доошгүй жил ажилласан, зөвлөх болон мэргэшсэн инженер байна.

7.1.2 Техникийн хяналтын үзлэгийн инженер нь автотээврийн инженер-механикч мэргэжилтэй, тухайн салбарт 3-аас доошгүй жил ажилласан, тухайн чиглэлээр мэргэшүүлэх сургалтанд хамрагдсан, мэргэшсэн инженер байна.

7.1.3 Техникийн хяналтын үзлэгийн техникч нь автотээврийн техникч-механикч мэргэжилтэй, тухайн чиглэлээр мэргэшүүлэх сургалтанд хамрагдаж гэрчилгээ авсан байна.

MNS 5044 : 2020

7.1.4 Техникийн хяналтын үзлэгийн инженер болон техникч нь үзлэгт хамрагдах тээврийн хэрэгсэлд тохирох ангилалтай, мэргэшсэн жолоочийн сургалтад хамрагдаж үнэмлэх авсан байна.

ТӨГСӨВ.